



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **БӨА-2025/040/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Өлгий хот

2025 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын,
дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigul@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн захирал: М.Нурболат
Утас: 70007275 Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТБОНӨБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМҮЗ	Эрүүл мэндийн үндэсний зөвлөл



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**БАЯННУУР СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Е.ЖАНЫЛ ТАНАА**

2025.02.24 № 172
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баяннуур сумын Эрүүл мэндийн төв нь 2024 онд 1,319.2 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1,164.7 сая төгрөг зарцуулж, 88.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 1 зорилго, 3 зорилтын хүрээнд нийт 15 арга хэмжээ, тусгай 2 зорилтын хүрээнд 7 тусгай арга хэмжээг төлөвлөж, 88 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	203,567,519.68	257,033,527.99
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	39,659.85	14,113.10
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	39,659.85	14,113.10
3121	Төгрөг	39,659.85	14,113.10
31211	Төрийн сангийн харилцах	39,659.85	14,113.10
33	АВЛАГА	19,649,755.00	105,258,557.20
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	3,635,879.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	19,649,755.00	101,622,678.20
35	БАРАА МАТЕРИАЛ	183,878,104.83	151,760,857.69
351	Түүхий эд материал	102,877,337.00	44,340,123.50
35130	Эм боох материал	102,877,337.00	44,340,123.50
354	Хангамжийн материал	81,000,767.83	107,420,734.19
35410	Бичиг хэргийн материал	1,807,100.00	2,535,300.00
35420	Аж ахуйн материал	61,567,167.50	80,507,174.56
35440	Түлш, шатах тослох материал	130,000.00	130,000.00
35460	Хүнсний материал	3,039,312.21	3,123,545.51
35470	Бусад хангамжийн материал	14,457,188.12	21,124,714.12
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	972,011,785.26	1,113,178,856.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	972,011,785.26	1,113,178,856.53
392	Биет хөрөнгө	966,243,785.26	1,106,640,856.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	824,562,603.82	853,762,603.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(90,938,980.62)	(103,246,911.10)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,606,056.00	183,243,389.35
39204	Хуримтлагдсан элэгдэл	(36,187,726.28)	(36,841,337.34)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	211,497,286.16	260,361,286.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32,546,116.00)	(88,017,662.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,094,128.80	52,345,568.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,943,466.62)	(15,066,080.68)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,601,500.00	5,601,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,601,500.00)	(5,601,500.00)
39217	Ном	100,000.00	100,000.00
393	Биет бус хөрөнгө	5,768,000.00	6,538,000.00
39301	Програм хангамж	550,000.00	1,320,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,768,000.00	5,768,000.00
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,175,579,304.94	1,370,212,384.52
4	НИИТ ӨР ТӨЛБӨР	43,976,723.00	91,368,283.25
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	43,976,723.00	91,368,283.25
413	Өглөг	43,976,723.00	91,368,283.25
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	8,128,907.00	8,644,349.00
4136	Бусад өглөг	35,847,816.00	82,723,934.25
41361	Байгууллагад төлөх өглөг	35,184,066.00	81,424,934.25
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	663,750.00	1,299,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,131,602,581.94	1,278,844,101.27
51	Засгийн газрын хувь оролцоо	1,131,602,581.94	1,278,844,101.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	481,899,043.00	481,899,043.00
51101	Өмч:- төрийн	481,899,043.00	481,899,043.00
512	Хуримтлагдсан үр дүн	207,475,349.23	355,044,322.56
51210	Өмнөх үеийн үр дүн	207,475,349.23	207,802,803.23
51220	Тайлант үеийн үр дүн	-	147,241,519.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	442,228,189.71	441,900,735.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,175,579,304.94	1,370,212,384.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	917,949,132.33	1,432,084,795.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,295,383.50	185,433,029.81
120	Нийтлэг татварын бус орлого	24,295,383.50	150,084,079.81
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,295,383.50	150,084,079.81
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,295,383.50	150,084,079.81
122	Тусламжийн орлого	-	35,348,950.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	35,348,950.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	893,653,748.83	1,246,651,765.20
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	51,060,500.00	58,400,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	51,060,500.00	58,400,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	842,593,248.83	1,188,251,765.20
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	842,593,248.83	1,188,251,765.20
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	927,208,043.34	1,283,767,375.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	927,208,043.34	1,283,767,375.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	926,259,543.34	1,283,767,375.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	580,793,899.00	832,524,799.00
210101	Үндсэн цалин	574,081,496.00	832,524,799.00
210102	Нэмэгдэл	2,512,403.00	-
210104	Урамшуулал	4,200,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,284,660.98	106,431,219.00
210201	Тэтгэврийн даатгал	74,284,660.98	106,431,219.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,954,608.00	55,491,699.74
210301	Гэрэл, цахилгаан	3,950,522.00	3,508,699.74
210302	Түлш, халаалт	43,004,086.00	51,983,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64,749,407.00	65,095,796.00
210401	Бичиг хэрэг	6,725,286.00	4,967,100.00
210402	Тээвэр, шатахуун	46,777,483.00	49,440,096.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,507,465.00	2,040,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,803,657.00	4,401,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,935,516.00	4,246,450.00
2105	Нормативт зардал	114,238,263.30	142,654,674.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,157,314.00	128,362,357.50
210502	Хоол, хүнс	14,080,949.30	13,156,316.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,136,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,918,400.00	6,763,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,171,000.00	1,393,750.00
210604	Урсгал засвар	5,747,400.00	5,369,600.00
2107	Томилолт, зочны зардал	2,183,700.00	1,127,500.00
210702	Дотоод албан томилолт	2,183,700.00	1,127,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	492,840.00	319,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	103,160.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198,000.00	319,300.00

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	33,680.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,643,765.06	73,359,037.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,172,900.00	3,544,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,470,865.06	69,814,437.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	948,500.00	0.26
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	948,500.00	0.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	948,500.00	0.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(9,258,911.01)	148,317,419.33
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,075,900.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,075,900.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(1,075,900.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(9,258,911.01)	147,241,519.33

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	874,003,993.83	1,164,678,842.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	874,003,993.83	1,164,678,842.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	51,060,500.00	58,400,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	51,060,500.00	58,400,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	822,943,493.83	1,106,278,842.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	822,943,493.83	1,106,278,842.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	878,717,394.98	1,142,375,988.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	878,717,394.98	1,142,375,988.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	877,768,894.98	1,142,375,988.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	572,402,636.98	833,433,561.00
210101	Үндсэн цалин	377,486,202.98	555,373,596.00
210102	Нэмэгдэл	125,263,451.00	212,589,630.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,007,000.00	16,799,081.00
210104	Урамшуулал	55,645,983.00	48,671,254.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,682,500.00	108,642,894.00
210201	Тэтгэврийн даатгал	50,783,400.00	76,522,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,779,500.00	3,877,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,195,500.00	3,877,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,949,100.00	15,511,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,954,608.00	55,583,999.74
210301	Гэрэл, цахилгаан	3,950,522.00	3,600,999.74
210302	Түлш, халаалт	43,004,086.00	51,983,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	58,682,900.00	57,942,056.00
210401	Бичиг хэрэг	4,550,000.00	7,105,000.00
210402	Тээвэр, шатахуун	46,825,800.00	42,031,856.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,257,200.00	1,945,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,094,000.00	1,979,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,955,900.00	4,880,800.00

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	105,880,618.00	70,367,827.75
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	91,921,057.00	54,009,377.75
210502	Хоол, хүнс	12,264,561.00	13,348,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,695,000.00	3,009,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,106,392.00	6,016,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,699,000.00	1,520,850.00
210604	Урсгал засвар	4,407,392.00	4,496,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,917,700.00	1,127,500.00
210702	Дотоод албан томилолт	1,917,700.00	1,127,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	492,840.00	431,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	103,160.00	1,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198,000.00	429,300.00
210807	Газрын төлбөр	33,680.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,648,700.00	8,830,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,648,700.00	8,830,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	948,500.00	0.26
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	948,500.00	0.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	948,500.00	0.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(4,713,401.15)	22,302,853.25
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,669,500.00	22,328,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,669,500.00	22,328,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,669,500.00	22,328,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,669,500.00	22,328,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(22,669,500.00)	(22,328,400.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(27,382,901.15)	(25,546.75)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,422,561.00	39,659.85
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	39,659.85	14,113.10
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	874,003,993.83	1,164,678,842.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	481,899,043.00	442,228,189.71	216,734,260.24	1,140,861,492.95
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	481,899,043.00	442,228,189.71	216,734,260.24	1,140,861,492.95
Тайлант үеийн үр дүн	-	-	(9,258,911.01)	(9,258,911.01)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	481,899,043.00	442,228,189.71	207,475,349.23	1,131,602,581.94
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	481,899,043.00	442,228,189.71	207,475,349.23	1,131,602,581.94
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	327,454.00	327,454.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	481,899,043.00	442,228,189.71	207,802,803.23	1,131,930,035.94
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(327,454.00)	-	(327,454.00)
Тайлант үеийн үр дүн	-	-	147,241,519.33	147,241,519.33
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	481,899,043.00	441,900,735.71	355,044,322.56	1,278,844,101.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	39,659.85		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,319,217,800.00	1,164,704,388.49	154,513,411.51	88.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,319,217,800.00	1,164,704,388.49	154,513,411.51	88.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,319,217,800.00	1,164,704,388.49	154,513,411.51	88.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	936,844,000.00	833,433,561.00	103,410,439.00	89.0
210101	Үндсэн цалин	550,506,000.00	555,373,596.00	(4,867,596.00)	100.9
210102	Нэмэгдэл	298,732,800.00	212,589,630.00	86,143,170.00	71.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,504,000.00	16,799,081.00	(7,295,081.00)	176.8
210104	Урамшуулал	78,101,200.00	48,671,254.00	29,429,946.00	62.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,105,600.00	108,642,894.00	12,462,706.00	89.7
210201	Тэтгэврийн даатгал	82,351,800.00	76,522,000.00	5,829,800.00	92.9
210202	Тэтгэмжийн даатгал	9,688,500.00	8,854,894.00	833,606.00	91.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,844,200.00	3,877,500.00	966,700.00	80.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,844,200.00	3,877,500.00	966,700.00	80.0
210205	Эрүүл мэндийн даатгал	19,376,900.00	15,511,000.00	3,865,900.00	80.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,943,800.00	55,583,999.74	359,800.26	99.4
210301	Гэрэл, цахилгаан	3,601,000.00	3,600,999.74	0.26	100.0
210302	Түлш, халаалт	52,342,800.00	51,983,000.00	359,800.00	99.3
2104	Хангамж, бараа материалын зардал	61,344,800.00	57,942,056.00	3,402,744.00	94.5
210401	Бичиг хэрэг	7,105,000.00	7,105,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	45,609,600.00	42,031,856.00	3,577,744.00	92.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,945,000.00	1,945,000.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,804,400.00	1,979,400.00	(175,000.00)	109.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,880,800.00	4,880,800.00	-	100.0
2105	Нормативт зардал	83,865,400.00	71,767,827.75	12,097,572.25	85.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	69,130,400.00	55,409,377.75	13,721,022.25	80.2
210502	Хоол, хүнс	11,463,600.00	13,348,650.00	(1,885,050.00)	116.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,271,400.00	3,009,800.00	261,600.00	92.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,483,600.00	22,286,850.00	21,196,750.00	51.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	38,980,100.00	17,790,850.00	21,189,250.00	45.6

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	4,503,500.00	4,496,000.00	7,500.00	99.8
2107	Томилолт, зочны зардал	2,417,700.00	1,127,500.00	1,290,200.00	46.6
210702	Дотоод албан томилолт	2,417,700.00	1,127,500.00	1,290,200.00	46.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	724,200.00	431,000.00	293,200.00	59.5
210803	Даатгалын үйлчилгээ	103,200.00	1,700.00	101,500.00	1.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,000.00	-	98,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	-	60,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	429,300.00	429,300.00	-	100.0
210807	Газрын төлбөр	33,700.00	-	33,700.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,488,700.00	13,488,700.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,488,700.00	13,488,700.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,319,217,800.00	1,164,678,841.74	154,538,958.26	88.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	58,759,800.00	58,399,999.74	359,800.26	99.4
132001	Орон нутгийн төсвөөс	58,759,800.00	58,399,999.74	359,800.26	99.4
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,260,458,000.00	1,106,278,842.00	154,179,158.00	87.8
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,260,458,000.00	1,106,278,842.00	154,179,158.00	87.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		39,659.85	(39,659.85)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		14,113.10	(14,113.10)	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	37	41	(4)	110.8
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	27	28	(1)	103.7
620003	Үйлчлэх ажилтан	9	12	(3)	133.3

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баяннуур сумын Эрүүл мэндийн төв нь “Эмнэлгийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай, үзүүлэх үйлчлүүлэгчийн эрхийг дээдлэхэд оршино” гэсэн эрхэм зорилготой байгууллага юм.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, оношилгоо шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх,
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тогтмол хүргэх
- Эхийн эндэгдэл гаргахгүй байх, эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах
- Хүүхдийн эндэгдлийг буруулах
- Халдварт болон халдварт бус өвчнийг буруулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баяннуур сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/
- Засгийн газрын 2024.02.28-ний өдрийн Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 84 дүгээр тогтоол,
- Засгийн газрын 2024.03.27-ний өдрийн Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 128 дугаар тогтоол,
- Эрүүл мэндийн үндэсний зөвлөл (ЭМҮЗ)-ийн 2024 оны Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 05 дугаар тогтоол,
- Эрүүл мэндийн үндэсний зөвлөл (ЭМҮЗ)-ийн 2024 оны Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 06 дугаар тогтоол.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд мэргэжлийн байгууллагуудаас ямар нэгэн хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус эрүүл мэндийн төвийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/05 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон ажиллаж байна. Энэхүү нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан хууль эрхийн актуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 194,633.1 мянган төгрөгөөр буюу 16.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	39.7	14.1	(25.6)
Авлага	19,649.8	105,258.6	85,608.8
Бараа материал	183,878.1	151,760.9	(32,117.2)
Үндсэн хөрөнгө	972,011.8	1,113,178.9	141,167.1
Нийт хөрөнгө	1,175,579.4	1,370,212.5	194,633.1
Өр төлбөр	43,976.7	91,368.3	47,391.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,131,602.6	1,278,844.1	147,241.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,175,579.3	1,370,212.4	194,633.1

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, авлага, эздийн өмчийн данс байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 85.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 1,164,678.8 мянган төгрөгийн санхүүжилт авч 1,142,375.9 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 105,258.6 мянган төгрөг болж 85,608.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 1,188,251.7 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж, Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,106,278.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, санхүүжилтээ дутуу авсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 151,760.9 мянган төгрөг болж 32,117.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 6,641.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, урсгал санхүүжилтээс 170,476.2 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 165,547.2 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулж 40,078.1 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,113,178.9 мянган төгрөг болж, 141,167.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 178,792.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 33,265.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 1,075.9 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг данснаас хасаж, 69,814.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 47,391.6 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт дутуу авсантай холбоотой харилцагч байгууллагуудад төлөх /эм, тээвэр шатахуун, ХАОАТ өглөг/ өглөг 91,368.3 мянган төгрөг болж нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/1,278,844.1 мянган төгрөг болж 147,241.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлан оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,864,542.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 62,800.0 мянган төгрөг, нийт зарлагыг 1,927,342.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 75,810.8 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 8,469.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 16,413.1 мянга, хангамж, бараа материалын зардлыг 4,678.5 мянга, норматив зардлыг 11,942.8 мянган, эд хогшил, урсгал засварын зардлыг 1,643.7 мянган, томилот, зочны зардлыг 442.0 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 462.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,864.9 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн хэмнэлт гаргахыг зорьсонтой холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71602 хөтөлбөрийн 80302 арга хэмжээг санхүүжүүлэхээр 749,589.0 мянган төгрөг, 81603 арга хэмжээний төгрөгийг тусламж үйлчилгээний орлогоос 356,689.7 мянган төгрөг, 58,400.0 мянган төгрөгийг орон нутгийн санхүүжилтээс авсан байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг эрүүл мэндийн даатгалын сангаас 1,260,458.0 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 58,759.8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төсөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2024 оны эхний үлдэгдлээс 39.6 мянган төгрөг Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,106,278.8 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 58,400.0 мянган төгрөгийн нийт 1,164,678.8 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулсан байна. Зарцуулаагүй 14.1 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй байна.

Нийт төсвийн гүйцэтгэл 1,164,704.4 мянган төгрөг буюу 88.3 хувьтай байгаа нь Нэг иргэнд ноогдох норматив төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийг 80,828.6 мянган төгрөг, Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний төсвийг 73,310.9 мянган төгрөг, Төрийн өмчийн

барилгын тогтмол зардлыг 359.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2.Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнд ноогдох норматив	830,417.7	749,589.1	80,828.6	90.3
2	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	430,040.3	356,715.3	73,325.0	82.9
3	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	58,759.8	58,400.0	359.8	99.4
	Дүн	1,319,217.8	1,164,704.4	154,513.4	88.3

Хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 88.3 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

2024 оны төсвийн жилд 170,476.0 мянган төгрөгийн бараа материал, 22,328.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авалтын хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотойгоор худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу төлөвлөж зохион байгуулах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Лайт энд Дилайт Аудит” ХХК-ийн аудитор Л.Мөнхцэцэг гүйцэтгэж, аудитын менежер Ц.Төмөрсүх, компанийн захирал М.Нурболат нар анхан шатны чанарын хяналтыг, Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 927,208.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,908.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 14 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш нийт 31 удаагийн 1,147,493.2 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ мэдээлэхээс 18 удаагийн 761,687.1 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг хугацаа хоцроосон, 13 удаагийн 385,506.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулах албан шаардлага хүргүүлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар эхний хагас жилийн санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 69,814.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав.

Залруулга: Тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн 69,814.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцсон байсныг нөхөж элэгдэл байгуулав.

Аудитаар нийт 385,506.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 385,506.0 мянган төгрөгийн албан шаардлага өгсөн.

5.1 Зөвлөмж:

1. Худалдан авалттай холбоотой

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (ТБОНӨБАҮХАТ)-ийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч ш ууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.5 "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно", 45 дугаар зүйлийн 45.3. "Энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад хамаарахгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд төсвийн шууд захирагч захиалагч байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

1.2. Зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛГИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Загруулсан		Үүнээс Загруулаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн 69,814.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцсон байсныг нөхөж элэгдэл байгуулав	1	69,814.4	1	69,814.4	-	-	1	69,814.4	-	-	-	-
ДҮН	1	69,814.4	1	69,814.4	-	-	1	69,814.4	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацаанд худалдан авах ажиглалааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй, шууд худалдан авалт хийсэн байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
ДҮН	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш нийт 31 удаагийн 1,147,493.2 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ мэдээлэхээс 18 удаагийн 761,687.1 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг хугацаа хоцроосон, 13 удаагийн 385,506.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.	1	385,506.0	-	-	1	385,506.0	-	-
ДҮН	1	385,506.0	-	-	1	385,506.0	-	-